



**“УЛААНБААТАР БУК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 18-ны өдөр

№ХЭХ 2024/..01

Улаанбаатар хот

Г2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан
дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Компанийн дүрмийн 7.6.9
дахь заалт, Тооллогын комиссын дүгнэлтийг тус тус үндэслэн,

ТОГТООХ НЬ:

1. “Улаанбаатар БУК” ХК-ийн 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг
“хангалттай” гэж баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.НЯМХҮҮ





**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 18-ны өдөр

№2024/02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 7.6.1 дэх заалтыг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. “Улаанбаатар Бүк” ХК-ийн дүрмийн холбогдох заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулж нэгдүгээр дүгээр Хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэн, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал Х.Золжаргал-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.НЯМХҮҮ

“УБ БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
2024 оны 04-р сарын 18-ны өдрийн хурлын № тоот
УЛААНБААТАР БҮК ХК-ийн хавсралт



**“УЛААНБААТАР БҮК” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРМИЙН
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1. Компанийн дүрмийн 7.54 дэх заалтад:

7.54. “ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Үйлдвэрлэл эрхэлсэн захирал, ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий инженер зэрэг Гүйцэтгэх захирлын удирдлагын багийн гишүүдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно”

2. Компанийн дүрмийн 7.2 дахь заалтад:

7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

3. Мөн “Аудитын хороо” гэснийг “Аудит эрсдлийн хороо” гэж өөрчлөн дүрэмд тусгах



**“УЛААНБААТАР БУК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 18-ны өдөр

№2024/03..

Улаанбаатар хот

ГТөлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дугаар заалт, Тооллогын комиссын дүгнэлтийг тус тус үндэслэн,

ТОГТООХ НЬ:

1. Доорх нэр бүхий хүмүүсийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд сонгосугай.

Ердийн гишүүд:

1. Д.Нямхүү
2. Д.Мөнхөө
3. Х.Золжаргал
4. Х.Ю.Хамхоев
5. О.Басанхүү
6. М.А.Чапанов

Хараат бус гишүүд

1. С.Б.Громов
2. Г.Цогнэмэх
3. Ч.Энхбат

2. Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэхийг ТУЗ-ийн гишүүдэд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.НЯМХҮҮ





**“УЛААНБААТАР БУК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 18-ны өдөр

№ ХЭХ 2024/04.....

Улаанбаатар хот

Г Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62 дугаар зүйлийн 62.1.16,
Компанийн дүрмийн 7.6.13, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг **357,324,000** / гурван зуун тавин долоон сая гурван зуун хорин дөрвөн мянган / төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.НЯМХҮҮ